

ТАНИЛЦУУЛГА




ЯАГААД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОМ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал сайн байх хэрэгтэй. Эрүүл мэндийн байдал сайн байх нь өвчингүй байхаас илүү чухал. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн эрүүл мэндийн байдал сайн байна гэдэг бол тухайн эмэгтэй өөрийн бие бялдар, оюун санаа, дотоод сэтгэлээрээ төгс сайхан байна гэсэн үг.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бие махбодид нь нийцтэй эрүүл мэндийн мэдээлэл байх аваас өөрийн эрүүл мэндэд санаа тавьж чадна. Мөн тэд энэхүү эрүүл мэндийн мэдээллээ ашиглаж хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүст нөлөөлж чадна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд амьдралдаа үүрэг хариуцлага хүлээгээд эхэлмэгц нийгэм олон нийтийн дэмжлэг, хүндлэлийг авч эхлэх болно.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд ямар нэг асуудал тулгарахад тэдний хөгжлийн бэрхшээлтэй байдалд анхаарал хандуулж тухайн эрүүл мэндийн асуудал нь “ноцтой биш” гэж үзвэл эмчлэгдэхгүй орхидог олон тохиолдол байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нь тулгарч буй өчүүхэн жижиг гэх асуудлыг эмчлэхгүй орхисоноор насан туршийн эмгэг үүсгэж болохыг хэлж байгаа юм.

Бид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг “эрүүл” байлгахад тулгардаг бэрхшээлийг устгах ёстой.



—Лизи Лоншау,
Зимбабын хөгжлийн
бэрхшээлтэй хүмүүсийн
Үндэсний зөвлөх

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХАД ТОХИОЛДДОГ БЭРХШЭЭЛҮҮД

Ихэнх эмэгтэйчүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах хүндрэлтэй байдаг.

Эрүүл мэндийн төвийн ойролцоо амьдардаг, үйлчилгээний хөлсийг төлөх хангалттай мөнгөтэй ч ихэнх эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хүн бүрт тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх орчинг бүрдүүлээгүй байдаг. Эрүүл мэндийн төвд очиход хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд олон төрлийн саад учирдаг. Үүнд:

- Тэргэнцэртэй хүмүүст зориулсан налуу шат байдаггүй
- Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан Брайл үсгэн эсвэл аудио хуурцаг дээр бичигдсэн мэдээлэл байдаггүй
- Сонсголгүй хүмүүсийн дохионы хэлийг мэддэг хэлмэрч байхгүй
- Юм сурах ойлгохдоо муу эмэгтэйчүүдэд туслах хүн байдаггүй зэрэг олон бэрхшээлийг энд дурьдаж болно.

Нийтлэг тохиолддог өөр нэг бэрхшээл бол эмч эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тохиолдож болзошгүй эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагыг ойлгох арга барилд суралцаагүй байдаг. Үүнээс болоод эмч эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үйлчилгээг авахад нь эвгүй байдалд оруулах, тэднийг гомдоох асуудал гардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд боловсрол эзэмшихгүй, өөрийн нөөц бололцоог дайчлахгүй, мэдэхгүй байх тусам эмзэг, дорой, бусдад ашиглуулж дээрэлхүүлж амьдардаг. Эрхээ мэдэхгүй, урам зориггүй амьдрал нь тэндийг нийгмээс шахагдахад хүргэдэг. Энэ байдал нь тэднийг эрүүл мэндийн тусламж авахад илүү саад учруулах хүчин зүйлийг бий болгодог.

ЭНЭХҮҮ НОМ ХЭНД ЗОРИУЛАГДСАН БЭ?

Энэ номыг зүй зохистой, эелдэг боловсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч чадахгүйгээсээ болж шаналж буй дэлхийн сая сая эмэгтэйчүүдэд зориулсан билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрийн эрүүл мэндэд илүү анхаарах, ерөнхий эрүүл мэндийн байдал нь сайжрах, тэдний авъяас чадвар, өөртөө итгэх итгэл нь нэмэгдэн нийгмийн амьдралд илүү идэвхитэй оролцоход энэ ном тус болно. Энэхүү ном нөхөн сэргээх гарын авлага биш бөгөөд өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээлийг оношлох, эмчлэхэд шаардлагатай мэдээлэл агуулаагүй өөр зорилготой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрүүл эмэгтэйчүүдтэй ижил боловч эрүүл мэндийн хэрэгцээ, түүнийг шийдвэрлэх арга нь арай өөр болохыг энэ номноос олж мэдэх болно. Хамгийн гол нь энэ номд багтсан мэдээллээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бусдаас арай илүү халамж авахад нь тус болно.

Хөгжлийн бэрхшээл гэдэг нь өвчтэй гэсэн үг биш юм. Энэ ном харааны бэрхшээлтэй, эсвэл тэргэнцэртэй эмэгтэй ч гэсэн эрүүл эмэгтэйчүүдийн нэгэн адил ХДХВ/ДОХ, хумхаа зэрэг өвчин тусч болох боломжтой гэдгийг эрүүл мэндийн ажилтнууд мөн гэр бүлийн гишүүд, асран халамжлагч нарт ойлгуулахад маш их тус болно.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг асран халамжилдаг гэр бүл, найз нөхөд, эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан хэн бүхэнд энэ ном ашиг тусаа өгөх болно. Мөн энэхүү номонд хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй болоход нөлөөдөг нийгмийн шалтгаанууд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, тэдний гэр бүлийнхэн цаашлаад нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг олон нийтийн ташаа ойлголтуудыг хэрхэн өөрчлөх арга замуудын тухай мэдээллүүд багтсан.

Номыг аль болох үнэ цэнэтэй болгохын тулд дэлхий дээрх хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлага, итгэл үнэмшил, туршлагыг хуваалцахаас гадна тэдгээр эмэгтэйчүүд ямар зүйлийг илүү түлхүү оруулахыг хүсч байгаагаа бидэнтэй хуваалцсанд оршино. Тэдгээр эмэгтэйчүүд өөрсдийн дуу хоолой, туршлага, туулж өнгөрүүлсэн түүхээ бидэнтэй хуваалцсан нь энэхүү номыг бичихэд маш их тус болсон бөгөөд номын хуудас бүхэнд шингэсэн байгаа.



